

ЭНТРЕПЕНЕРШИПД СУУРИЛСАН СУРГАЛТ, АРГАЗҮЙН ТУРШИЛТ, ҮР ДҮН

*Ц. Жавзандулам
Магистр*

*Этүгэн их сургууль
Инженерчлэл-эдийн засаг, менежментийн сургууль*

javzandulamtseveendorj@gmail.com

*Б. Учрал
Магистр*

*Этүгэн их сургууль
Инженерчлэл-эдийн засаг, менежментийн сургууль*

uchral.b@etugen.edu.mn

Хураангуй: Эдийн засгийн хөгжлийг дэмжих чухал хүчин зүйл бол энтрепренершипийн боловсрол юм. Инновацид тулгуурласан эдийн засгийн гол хөдөлгөгч хүч нь мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээ, түүнийг бий болгож буй бизнес эрхлэгчид юм. Бодлого боловсруулагчид гарааны бизнесийг чухалчилж их сургууль, коллежийн оюутнуудын бизнес эрхлэх үйл ажиллагааг дэмжиж байна.

Иймд энтрепренершип боловсрол олгоход суралцахуйн онол, сургалтын аргазүй, үнэлгээг оновчтой сонгож хэрэгжүүлэх нь эн тэргүүнд тавигдаж байна. Энэхүү ажлаар бизнесийн практикт ашиглаж буй *Design thinking* аргачлал, *Concept board* дижитал самбарыг сургалтанд туршсан. Энтрепренершипид суурилсан сургалтын үр дүнд суралцагсдын хувь хүний ур чадвар хэрхэн нэмэгдсэн талаар өгүүлнэ.

Түлхүүр үгс: Энтрепренершип, экспансив, загварчлах сэтгэлгээ, 19 ур чадвар

УДИРТГАЛ

Менежментийн загалмайлсан эцэг гэгддэг Петер Дракер 1964 нд “Энтрепренерүүд өөрчлөлтийг эрэлхийлэн түүнийгээ олж, боломжийг ашигладаг. Тэдний гол зэвсэг бол инновац” гэсэн тодорхойлолтыг өгчээ. Dictionary.com- д эрсдэлтэйгээр болон идэвх санаачилгатайгаар компани буюу бизнесийг удирдан зохион байгуулж буй хүнийг хэлнэ. Их британийн тэр бумтан Virgin группыг үндэслэгч Mr.YES Richard Branson “Энтрепренер байна гэдэг нь энгийнээр хүмүүсийн амьдрах орчинг илүү таатай амар болгохыг хүсдэг нэгэн байна гэсэн үг”, Даллас Маверикс багийн эзэн, хөрөнгө оруулагч Марк Кубан “Ямар бизнес хийхээ, хаана хүрэхээ, тийшээ хэрхэн хүрэхээ тодорхойлж чаддаг хүнийг энтрепренер гэнэ. Ямар бизнес хийхээ, хаана хүрэхээ, тийшээ хэрхэн хүрэхээ

тодорхойлж чаддаг хүнийг энтрепренер гэнэ.” Дэлхийн хамгийн том санхүүгийн хэвлэл мэдээллийн байгууллагын үндэслэгч Майкл Блүүмберг “Энтрепренер байна гэдэг нь заавал бизнес эхлүүлэхийн нэр биш. Энэ нь бусдын бэрхшээл гэж харж буйг боломж болгон хувиргаж, тэдний тойрч буй эрсдэлийг үүрч гарахын нэр юм”. Дэлхий дахинаа Томас Эдисон, Хенри Форд, Стив Жобс, Элон Маск, Марк Зукерберг, Жеф Безос, Тони Шейгэх мэт маш олон энтрепренерүүд төрөн гарсан бөгөөд тэдний хийж бүтээсэн зүйлс хүн төрөлхтөнд өндрөөр үнэлэгдэж байна.

Зорилго: Энтрепренершипд суурилсан сургалтаар суралцагчдын мэргэжлийн 19 ур чадварыг хөгжүүлэх

Бизнес эрхлэх сургалтын онол: Экспансив онол

Хичээлийн агуулга: Design thinking –ны 5 E үе шат (Explore, Empathize, Experiment, Engage, Evolve)

Аргазүй: Төсөлд суурилсан аргазүй

Аргачлал: Загварчлах сэтгэлгээ (Design thinking)

Судалгааны объект: Бизнес төсөл хичээл

Судлагдахуун: Суралцагчийн сэтгэлгээ, ур чадварт гарч буй өөрчлөлт

Таамаглал: “Бизнес төсөл” хичээлд загварчлах сэтгэлгээ “Design thinking” аргачлалыг ашигласнаар суралцагчдын “хувь хүний ур чадварыг нэмэгдүүлнэ”.

1. Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтын онол, аргазүйн үндэс

Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалт нь Нийгэм сэтгэл хөдлөлийн суралцахуй, 21 дүгээр зууны ур чадвар, Энтрепренершип боловсрол, болон Нийгмийн инновацийн боловсрол гэсэн 4 үзэл баримтлалд үндэслэнэ. Сүүлийн жилүүдэд эдгээр үзэл баримтлалыг тус тусад нь гэхээс амжилттай суралцах, ажиллах, амьдрахад шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагыг хөгжүүлэхэд цогцоор нь судалдаг болсон байна. Энтрепренершип гэдэг нь бусдад зориулан үнэт зүйл бий болгох замаар тодорхой хэрэгцээг шийдэх боломж болон санааг хэрэгжүүлэх чадамж юм [1]. Энтрепренершип гэдэг нь бүтээлчээр сэтгэж, шинэ зүйл санаачлан, ашиг олох, зорилгоор бизнес эрхлэх үйл ажиллагаа [2].

Энтрепренершип гэдэг нь нийгмийн, соёлын, бизнесийн ямар нэг үнэт зүйлийг бий болгох чиглэлээр шинэ, инновацийн санаа дэвшүүлэх, боломжийг эрэлхийлэх процесс гэж үзвэл энтрепренершипийн сургалт нь товчхондоо суралцагчдад шинэ, инновацийн мэдлэг, үнэт зүйл, зан үйл бүтээх, түүнийг хэрхэн бүтээх арга зам, ур чадварт суралцахад чиглүүлэх, дэмжих үйл явц юм [3]. Энтрепренершипийг "динамик сургалтын үйл явц" гэж үзвэл энтрепренершипийн онол нь суралцах онолыг шаарддаг [4].

Scopus мэдээллийн сангийн 21 сэтгүүлийн нийтлэл дэх энтрепренёршипийн сургалтанд хэрэглэж буй суралцахуйн онолыг судалж үзэхэд (а) Дьюигийн "хийх замаар суралцах", (б) Колбын туршлагаас суралцах, (в) Мезириовын хувиргах сургалт, (г) Лав, Венгер нарын байрлалд суралцах арга, (д) Engeström-ийн өргөн хүрээтэй сургалтыг хослуулан ашиглаж байна.

Энтрепренерийн боловсролын талаар хийгдсэн судалгаагаар энэ нь уламжлалт сургалтаас нэлээд өөр юм. Учир нь энтрепренершипийн сургалт илүү шинэлэг, инновацлаг бөгөөд суралцагчдын үйл, идэвхтэй үйл ажиллагаанд суурилсан [5], бодит асуудлыг шийдэхэд чиглэсэн байдаг. Энтрепренершипд математик, хими, физик, нийгэм судлал, бизнес судлал зэрэг судлагдахууныг дан дангаар нь авч үзэх боломжгүй. Энэ нь суралцагчдаас нийлмэл ур чадвар шаарддаг, агуулгын хувьд интеграцчилагдсан, суралцагчдын хамтын ажиллагаа, зөвшилцөл, шийдвэр гаргалтыг нэлээд их шаарддаг, төсөлт хэлбэрийн даалгавартай, сурах үйлийн явцыг чухалчилдаг. Тиймээс олон төрлийн хичээлийн мэдлэг, ур чадварын уулзвар дээр тодорхойлогддог, агуулгын хувьд нэлээд интеграцчилагдсан, суралцагчдын хамтын ажиллагаа, зөвшилцөл, шийдвэр гаргалтыг нэлээд их шаарддаг, төсөлт хэлбэрийн даалгавартай, сурах үйлийн явцад нэлээд ач холбогдолтой ханддаг юм [6]. Данийн эрдэмтэн, судлаач К.Иллерис суралцахуйн 16 онолыг судалсан бөгөөд тэр дундаас цөөн хэд нь энтрепренершипийн сургалтад хэрэглэх боломжтой гэж дүгнэсэн байдаг ба энэ дундаас хамгийн тохиромжтой нь экспансив суралцахуйн онол гэж үзжээ [7].

Экспансив суралцахуйн онолын хөгжүүлэгчээр Финландын Хелсинкийн их сургуулийн эрдэмтэн Энгерстром зүй ёсоор тооцогддог. Түүний тодорхойлсноор суралцагчид ямар нэг үйлийн системийн үндсэн ухагдахууныг дахин тодорхойлох, тухайн үйлийн өмнөх хэлбэрээс илүү өргөн хүрээний боломжийг багтаах үйлийн сэдэл бий болгох замаар хамтаараа *хувирган өөрчлөх* эсвэл *өргөтгөх үйл явц* юм [8].

Эндээс харахад суралцагчдад эргэлзэх, асуулт асуух, нэгэнт тогтсон жишиг, нормд шүүмжлэлтэй хандах, илүү үр дүнтэй байдлаар өөрчлөх гэж оролдох, олон талт байдлаар асуудалд хандах, асуудлын учир шалтгаан, үр дагаврыг эргэцүүлэх, шинэ загвар, практикийг санал болгох, гэх мэт суралцахуйн “хэвшмэл бус” үйл, сэтгэлгээг дэмжиж өгдөг тодорхой цикл бүхий сурах үйл ажиллагаатай үзэл баримтлал юм.

Энтрепренершип хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд экспансив суралцахуйн онол хамгийн тохиромжтой байдаг [9]. Экспансив суралцахуйн онол нь 3 онцлогтой. Үүнд:

1. Суралцахуй гэдэг нь утга учиртайгаа ямар нэг зүйлийг бүтээдэг, ингэхдээ таних мэдэхүйн арга хэрэгслийг хэрэглээг бүтээдэг үйл явц
2. Суралцахуй гэдэг нь суралцагчийн харилцан яриа, оролцоо, хамтын ажиллагааны үр дүн явагддаг үйл явц
3. Суралцахуй гэдэг нь одоо байгаа практикийн асуудлаа эргэж харж асуух, эргэлзэх, шүүмжлэлт байр сууринаас хандах замаар илүү шинэ санаа, эд зүйл, зан үйлийг бүтээдэг үйл явц

Энтрепренершип сургалтад багшийн үүрэг хамгийн чухал байдаг учраас багш өөрөө шинийг санаачлагч, бүтээгч, энтрепренер сэтгэлгээтэй, асуудлыг шийдэх, хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай, оновчтой ашигладаг энтрепренерүүд байх нь энэ сургалт амжилттай байх үндэс юм [10].

Экспансив суралцахуйд суралцагчид практикийн асуудалд шүүмжлэлт байр сууринаас хандаж, түүнийг сайжруулах, хөгжүүлэх шинэ санаа боловсруулах, түүнийгээ турших, боломжийг тодорхойлоход хамтаараа хүчин чармайлт гаргадаг учраас энэ суралцахуйг удирдан чиглүүлэх, хөтлөхөд төсөлд суурилсан арга зүй хамгийн тохиромжтой.

Суралцагчдын хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд хамгийн үр дүнтэй арга нь тэднийг бие биетэйгээ идэвхтэй харилцах, өөрийн санаа, хийсэн зүйлээ танилцуулах, илтгэх, үйл ажиллагаагаа зохион байгуулах, асуудлын учир шалтгааныг эрэлхийлэх, шинжлэх судлах, эргэцүүлэх, бодит амьдралын асуудлыг шийдэхэд татан оролцуулах явдал юм.

2. Сургалтын аргазүй ба загварчлах сэтгэлгээ (design thinking)

Экспансив суралцахуйн онолын хүрээнд энтрепренершипд суурилсан сургалтын үр дүнг дээшлүүлэх оночтой аргуудыг судалсан. Бизнесийн практикт өргөнөөр ашиглаж буй загварчлах сэтгэлгээ (design thinking) аргачлалыг сургалтандаа туршив.

Design Thinking буюу Загварчлах сэтгэлгээ гэдэг нь аливаа асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх философи ба арга хэрэгслүүдийн багц юм. Бизнесийн практикт ч энэ аргачлалыг байгууллагадаа инновацийг бий болгох, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор маш түгээмэл ашиглаж байна. Загварчлах сэтгэлгээ нь нээж илрүүлэх, тайлбарлах, санааг бий болгох, туршилт хийх, хувиргах гэсэн 5 үе шатаар хэрэгжихдээ экспансив суралцахуйн онолд үндэслэдэг. Загварчлах сэтгэлгээ гэдэг нь нэг талаасаа хүмүүсийг хайрцагнаас гадуур сэтгэж, бүтээлч, инновацилаг байдлаа сэргээх буюу үйлдэнгээ суралцах үйл явц юм. Нөгөө талаасаа зөвхөн бүтээгдэхүүн, үйлчилгээний загвар гаргахаас гадна байгууллагын систем, процедур, процесс, харилцагчийн туршлагыг дахин бүтээхэд ашиглагддаг.

Design Thinking буюу Загварчлах сэтгэлгээ-ний 5 үе шатны туршид Concept board дижитал самбарыг ашигласнаар суралцагсдын багаар ажиллах буюу хамтран суралцах үйл ажиллагаа идэвхжихийн зэрэгцээ дижитал ур чадваруудыг нэмэгдүүлсэн. Цахим сургалтын явцад суралцагсдын идэвх оролцоо нэмэгдсэнээр мэдлэг бүтээхэд чухал үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Түүнчлэн Энтрепренер сэтгэлгээ, ур чадварыг эзэмшихэд технологийн боломжийг бүрэн ашиглаж сурахад чиглэж байна. Хичээлийн хүрэх үр дүн болох мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлохоос гадна “Энтрепренер сэтгэлгээ”-г хөгжүүлэх дасгал ажлууд, багийн ажиллагаанд төвлөрч ажилласан.

Хүснэгт 6. Design thinking-ний үе шат ба сэтгэлгээний хэлбэрүүд

Үе шат	Загварчлах сэтгэлгээний үе шатууд	Холбогдох онолын чиглэл	Сэтгэлгээ хөгжүүлэх дасгал ажил
1	Explore - Нээж илрүүлэх	1.Дьюгийн “хийх замаар суралцах”	Сэтгэлгээний 6 малгай (Асуудлаа тодорхойлох)
2	Empathize - Гүн гүнзгий ойлгох	2.Колбын туршлагатай суралцах 3.Мезириовын хувиргах сургалт,	Цацаргах сэтгэлгээ (Тухайн асуудалтай холбоотой зүйлүүдийг олж холбох)
3	Engage -Санааг бий болгох	4.Лав Венгер нарын байрлалд суралцах арга	Бүтээлч сэтгэлгээ (бүтээлч шийдэл)
4	Experiment -Туршилт хийх	5.Энгстромын өргөн хүрээтэй сургалт	Системийн болон шүүмжлэлт сэтгэлгээ (санаагаа турших)
5	Evolve - Хувиргах		Латерал сэтгэлгээ (өөр хэрэглээ, зориулалт, нэмэлт онцлог шинж нэмэх)
Цахим хэрэглэгдэхүүн			Concept board дижитал самбар

Эх сурвалж. Судлаачийн боловсруулсан

3. Туршилт, судалгаа: Загварчлах сэтгэлгээ “Design Thinking” аргачлалын туршилт, үр дүн

Этүгэн их сургуулийн бүх мэргэжлийн хөтөлбөрт заавал судлахаар төлөвлөсөн 1 кр “Бизнес төсөл” хичээлийг судалсан суралцагсдын хувь хүний ур чадварыг хөгжүүлэх үүднээс “Design Thinking” аргачлалыг ашиглан 2022-2023 оны хичээлийн I улиралд туршив.

Z үеийнхэний онцлогт тохирсон сургалтыг зохион байгуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэх үүднээс технологийн дэвшилтэт хичээлийн цахим хэрэглэгдэхүүнийг ашиглах шаардлага бий болж байна. Нэн ялангуяа цахим сургалтыг танхимын сургалтаас дутахааргүй идэвх оролцоотой, бүтээлч хандлагатай, мэдлэг бүтээх, асуудал шийдвэрлэх, санаа гаргаж сурахыг ажлын байранд тавигдаж буй шаардлага харуулж байна. Практикаас харахад багш нар цахим поток семинарын хичээлийг гол төлөв блог, хэлэлцүүлгийн самбар, тэмдэглэл, вики ашиглахаас гадна сургуулийнхаа удирдлага мэдээллийн систем дээр ажиллаж байна. Сургалтын цахим орчинд шилжихтэй холбоотой цахим сургалтын аргазүй болон хэрэглэгдэхүүнийг эзэмших бодит хэрэгцээ үүссэн. Иймд цахим

сургалтанд дижитал самбарууднь хэрэглэхэд хялбар хэд хэдэн шийдлүүдийг санал болгодог хэрэгсэл юм.

Хичээлийн хүрэх үр дүн болох мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлохоос гадна “Энтрепренер сэтгэлгээ”-г хөгжүүлэх дасгал ажлууд, багийн ажиллагаанд төвлөрч ажилласан. Загварчлах сэтгэлгээ Design Thinking аргыг хэрэглэх явцад нэмж алхам бүрт тохирсон сэтгэлгээний хэлбэрүүдийг ашигласан. Түүнчлэн POEMS (people, object, environment, media & message, service) ажиглалтын аргыг ашиглан Pain points буюу хэрэглэгчийн шаардлагад нийцсэн шийдлүүдийг томъёолсон. Хэрэглэгчийн хэрэгцээг ойлгоход SPICE (social, physical, identify, communication, emotional) агуулгаар судлуулсан.

Сургалтын хэрэглэгдэхүүний хувьд дижитал самбар (Миро) ашиглан зохион байгуулсан нь багийн ажиллагаа болон цахим ур чадварыг дэмжсэн. Миро бол орчин үед багуудад өөр өөр цагийн бүс, формат, суваг, хэрэглүүртэй хамтран ажиллах цахим самбарын платформ юм. Энэхүү хэрэгсэл нь хамтран ажиллаж, санаа гаргаж буй багуудад маш тохиромжтой. Үүнээс гадна, энэ нь одоо бичиж тэмдэглэх, шийдвэр гаргахад санал өгөх, мэдээлэл цуглуулах, ажлаа хуваалцах гэх мэтээр ашиглахад нэн тохиромжтой. Concept Board нь видео болон аудио дуудлагын функцуудыг дэмждэг хүчирхэг хамтын ажиллагааны боломжуудыг өөртөө агуулдаг. Төлбөргүй хэрэглэгч бол зөвхөн 500 МБ хадгалах багтаамжийг ашиглах боломжтой. Мөн 50 зочин хэрэглэгч буюу оролцогч зөвхөн бүтээлийг уншиж, дүгнэх боломжтой. Энэхүү дижитал самбар нь MS Teams, Google drive, Drop box, Full Page Screenshot-той интеграц хийгдсэн төдийгүй цахим самбар, оюуны довтолгоо, уулзалт, семинар, төсөл, эжайл менежмент, загварчлах сэтгэлгээ (Design Thinking), стратеги төлөвлөлт боловсруулах багийн үйл ажиллагаанд ашиглахад тохиромжтой. Concept board нь энгийн бөгөөд цэвэр хэрэглэгчийн интерфэйс бүхий аудио болон видео дуудлага хийх, дэлгэц хуваалцах боломжийг санал болгодог давуу талтай. Үнэгүй хэрэглэх тохиолдолд нийт хадгалах зай нь 500МВ-аар хязгаарлагддаг сул талтай.

Bon Ku, Ellen Lupton (2022) нарын *Health Design Thinking Creating Products and Services for Better Health* номыг сургалтанд ашигласнаар эрүүл мэндийн салбарын буюу мэргэжлийн мэдлэгээ ашиглан бизнес эрхлэх боломжийг бий болгосон. Энтрепренершип сургалтын төгсгөлд танхимаас гадуур суралцаж буй суралцагчид Concept board ашиглан төслөө боловсруулж, PITCH буюу төслийн танилцуулга хийсэн. Нийт 3 мэргэжлийн 60 багийн төслөөс 42 нь эрүүл мэндийн салбарын асуудлыг шийдэхэд чиглэсэн нь мэргэжлийн мэдлэгээ ашиглан шинэ мэдлэг бүтээхэд суралцаж буй байдал юм.

Туршилтын үр дүн: 2022-2023 оны хичээлийн жилд “Бизнес төсөл” хичээлийн сургалтанд ашигласан сургалтын загварчлах сэтгэлгээ (Design thinking) арга нь тухайн мэргэжлийн хөтөлбөрийн 19 ур чадварыг хэрхэн дэмжсэн байдлыг тодруулах үүднээс Нүүр ам судлалын эмч бакалаврын 100, Ерөнхий анагаах, хүний их эмч бакалаврын 100, Эм зүйч бакалаврын 100 нийт 300 оюутныг судалгаанд хамруулсан. 20 асуулт бүхий асуумж боловсруулан Ликертийн шкал ашиглан 0-4 оноогоор үнэлэв. Хариултууд нь 0 огт санал нийлэхгүй, 1 санал бараг нийлэхгүй, 2 зарим талаараа санал нийлнэ, 3 санал нийлнэ, 4 санал бүрэн нийлнэ гэсэн байдлаар боловсруулсан. Асуулга дахь мэргэжлийн ур чадварын түвшин бүрт хамаарах өгөгдлүүдийг дараах дараалал, дугаараар тохируулсан болно.

Хүснэгт 7. Мэргэжлийн ур чадварын бүлэг ба өгөгдлийн дугаар

№	Мэргэжлийн ур чадварын бүлэг	Өгөгдлийн дугаар
1	Мэргэжлийн мэдлэг	1.1;1.2;1.3;1.4
2	Хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, хандлага	2.1;2.2;2.3;2.4
3	Хүмүүстэй харилцах багаар ажиллах ур чадвар	3.1;3.2;3.3;3.4
4	Салбар ба нийгэмд чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадвар	4.1;4.2;4.3;4.4

Найдвартай байдал: Асуумжийн найдвартай байдлыг шалгаж үзэхэд Cronbach's Alpha коэффициент .094 гарсан нь асуултууд болон дэд бүлгүүдийн уялдаа холбоо сайн, Бизнес төсөл хичээлийн хүрээнд сургалтын аргазүйн үнэлж болохуйц асуулга болсоныг харуулж байна.

Тохироц чанар: Ур чадварын үнэлгээний асуулгыг үр дүнд суурилсан мэргэжлийн хөтөлбөрийн 19 ур чадварын ангиллыг үндэслэн боловсруулсан. Судалгааны үр дүнд хийсэн **ялгах чадварын шинжилгээгээр** бүх оролцогч огт хариулаагүй, эсхүл бүгд ижил хариулсан ялгах чадваргүй өгөгдөл гараагүй болно.

Хүснэгт 8. Мэргэжлийн ур чадвар ба сургалтын үр дүн

19 ур чадвар	Ур чадварууд	Нүүр ам судлал	Хүний их эмч	Эм зүйч	Дундаж
II. Хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, хандлага					
4	Шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх чадвар	83	86	88	85.6
5	Туршилт хийх, мэдлэг бүтээх чадвар	92	82	87	87
6	Системтэйгээр бодох чадвар	88	78	85	83.6
7	Хувь хүний хандлага, байнга суралцах чадвар	90	93	94	92.3
8	Ёс зүйтэй байх, хариуцлага ухамсарлах чадвар	86	90	89	88.3
Дундаж		87.8	85.8	88.6	87.4
III. Хүмүүстэй харилцах, багаар ажиллах ур чадвар					
9	Багаар ажиллах	96	93	85	91.3
10	Харилцааны ур чадвар	87	90	92	89.7
11	Гадаад хэлээр харилцах чадвар	78	75	80	77.6

Дундаж		87	86	85.6	86.2
IV.Салбар ба нийгэмд чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадвар					
15	Үйл ажиллагааг төлөвлөх чадвар	81	82	85	82.6
16	Хэрэгжүүлэх, бүтээх чадвар	78	76	80	78
17	Хэрэглээ болгох чадвар	75	80	81	78.6
19	Энтерпренершип	86	84	88	86
Дундаж		80	80.5	83.5	81.3
Нийт ур чадваруудын дундаж		84.93	84.13	85.9	84.9

Бизнес төсөл хичээлийн хувь хүний ур чадварын асуулгад хүчин зүйлийн шинжилгээг (Principal component analysis-PCA) хийж, мэргэжлийн хөтөлбөрийн ур чадварын түвшинг харгалзан 4 фактор, факторын оноог **0,4** байхаар тохиргоо хийгдсэн. Тус шинжилгээгээр КМО тестийн үр дүн **802**, $p=.000$ гарсан нь фактор бүрийн хувьд хангалттай хувьсагч хамрагдаж тэдгээр нь хоорондоо хамааралтай ба ач холбогдолтой болохыг харуулж байна. Мөн өөрийн үнэлгээний хэлбэлзэл өөрчлөлтийг **71.646** хувь нь энэхүү 4 фактороор тайлбарлагдана гэсэн тооцоолол гарав.

Нүүр ам судлал, хүний их эмч, эмзүйч мэргэжлийн хөтөлбөрийн хүрэх үр дүн болох Хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, хандлагын дундаж (4,5,6,7,8) **87.4**; Хүмүүстэй харилцах, багаар ажиллах ур чадварын дундаж (9,10,11) **86.2**; Салбар ба нийгэмд чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадваруудын дундаж (15,16,17,19) **81.3** байгаа нь энтерпренершипд суурилсан сургалтын үр нөлөө хувь хүний ур чадварыг хэрхэн дэмжиж байгааг харуулж байна. Нийт 19 ур чадвараас 12 ур чадварыг ямар нэгэн байдлаар дэмжсэн бөгөөд мэргэжил бүрээр авч үзвэл нүүр ам судлал мэргэжлийн хөтөлбөрийг дэмжсэн дундаж үнэлгээ **84.93%**, ерөнхий анагаах ухаан, хүний их эмч **84,13%**, эм зүйч **85.9%** бөгөөд энэ гурван мэргэжлийн хөтөлбөрийн дундаж нь **84.9%**-тайгаар дэмжиж байна. Түүнчлэн сонгосон 3 мэргэжлийн хөтөлбөрийн 19 ур чадварын хоорондын зөрүү маш бага байна. Энэхүү сургалтын аргачлал нь суралцагчдад ойролцоо нөлөө үзүүлж байгааг илтгэж байна. Учир нь сургалтын үйл ажиллагаанд суралцагч бүрийг татан оролцуулж, өөрөөр нь сэтгэж бодох боломжийг олгож, тэдний үзэл бодлыг хүлээн зөвшөөрснөөс ийм үр дүнд хүрсэн байна.

ДҮГНЭЛТ

Суралцагчид мэргэжил үл харгалзан бизнес эрхлэх талаар тодорхой мэдлэг, ур чадвар эзэмшихид загварчлах сэтгэлгээний үе шат бүрт тохирсон сэтгэлгээ шаардахуйц үйлүүдийг төлөвлөж ажилласан нь өмнөх мэдлэг, ур чадвар, туршлагаа ашиглан хамтдаа асуудлын шийдлийг төсөл хэлбэрээр шийдэж сурсан. Энэхүү сургалтын арга нь суралцагч төвтэй сургалтын хэлбэр төдийгүй “суралцахуйд суралцсан” үйл явц байлаа.

Design thinking аргаар энтрепренершип сургалтыг зохион байгуулсан нь сургалтын үр дүнд эерэгээр нөлөөлөөд зогсохгүй ирээдүйд бизнесийн талбарт хамтран ажиллах багтайгаа ойлголцох, хамтран ажиллах, цахим орчинд хамтран суралцах, асуудлыг шийдвэрлэх ур чадваруудыг хөгжүүлсэн байна. Дүгнэж хэлэхэд “Бизнес төсөл” хичээлд загварчлах сэтгэлгээ “Design thinking” аргачлалыг ашигласнаар $P(\text{sig})=0.000$ суралцагсдын “хувь хүний ур чадварыг нэмэгдүүлнэ” гэсэн үндсэн таамаглалыг хүлээж авах боломжтой болж байна.

НОМ ЗҮЙ

- [1]. J. Cope, "Toward a Dynamic Learning perspective of Entrepreneurship," *Entrepreneurship Theory and Practice*, 29, pp. 373-397, 2005
- [2]. Osrewalder,A and Pigneur,Y, *Business model generation: a handbook for visionaries, game channers, and challengers*, John Wiley & Sons, 2010
- [3]. A. Gibb, "in pursuit of a new `enterprise` and `entrepreneurship` paradigm for learning: creative destruction, new values, new ways of doing things and new cominations of knowledge.," *International Journal of Management Reviews*,4, pp. 233-269, 2002
- [4]. Minniti,M and Byhrave,W, "A dynamic models of entrepreneurial learning," *Entrepreneurship Theory and Practice*, 25, pp. 5-16, 2001
- [5]. E. Mwasalwiba, "Entrepreneurship education:a areview of its objectives, teaching methods, and impact indicators," *Education & Training*, 52, pp. 20-47, 2010
- [6]. M. Lackeus, "an emotional based approach to assessing entrepreneurial education," *International Journal of Management Education* , In press, 2015
- [7]. A. leont`ev, *Problems of the development of the mind*, Moscow: Progress, 1981
- [8]. Y. Engestrum, "The horizontal dimension of expansive learning:Weaving a texture of cognitive trails in the terrain of health care in Helsinki," *Volume 1: The teaching-learning perspective* .Bielefeld:Bertelsmann , pp. 30-31, 2003
- [9]. Illeris.K, *How We Learn:Learning and Non-Learning in School and Beyond*, London: Routledge, 2007
- [10]. Heinonen,J and Hytti,U, "Back to basics: the role of teaching in developing the entrepreneurial university," *The International Journal of Entrepreneurship and Innovation*, 11, pp. 283-292, 2010